



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код:
БНА-2023/112/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 07</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Азбаяр Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
.....
 - 4.2 Материаллаг байдал
.....
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТАГ	Төрийн аудитын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.17 № 2/46

танай _____-ны № _____-т

Г _____ Г

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ М.МАЙЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор аймгийн Прокурорын газрын байр буюу Шүүхийн тамгын газрын албан конторын 3 дугаар давхрын дотоод засварыг хийхээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс төсвийн хуваарьт 2 удаагийн нэмэлт өөрчлөлтийг оруулж 42,528.6 мянган төгрөгийг баталж барилгын засвар үйлчилгээний ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгүүлэхдээ тендер зарлахгүйгээр хэсэгчлэн шууд гэрээ байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар нь 2022 оны гүйцэтгэлийн

005020238

төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны 12 тоот тушаалаар 73,9 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд толилууагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	27,671,180.00	41,310,400.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	8,000,000.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	8,000,000.00
3121	Төгрөг	-	8,000,000.00
31211	Төрийн сангийн харилцах	-	8,000,000.00
33	АВЛАГА	483,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	483,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	27,188,180.00	33,310,400.00
354	Хангамжийн материал	27,188,180.00	33,310,400.00
35410	Бичиг хэргийн материал	5,615,622.00	6,304,302.00
35420	Аж ахуйн материал	17,964,278.00	24,422,348.00
35440	Түлш, шатах тослох материал	2,282,980.00	900,000.00
35450	Барилгын засварын материал	-	358,450.00
35470	Бусад хангамжийн материал	1,325,300.00	1,325,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	598,184,442.22	921,977,972.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	598,184,442.22	921,977,972.36
392	Биет хөрөнгө	534,913,442.27	858,906,972.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	492,054,510.19	757,989,069.19
39202	Хуримтлагдсан элэгдэл	(98,901,768.97)	(121,312,246.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	140,936,000.00	90,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(80,769,333.35)	(15,950,000.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	210,855,895.01	175,886,667.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(157,699,952.03)	(58,371,383.84)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,106,235.12	103,269,404.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(72,664,143.70)	(75,790,538.18)
39214	Бусад үндсэн хөрөнгө	189,400.00	189,400.00
39217	Ном	2,806,600.00	2,996,600.00
393	Биет бус хөрөнгө	63,270,999.95	63,070,999.91
39301	Программ хангамж	1,891,000.00	1,825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,141,000.05)	(1,275,000.09)
39303	Бусад биет бус хөрөнгө	62,521,000.00	62,521,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	625,855,622.22	963,288,372.36
413	Өглөг	483,000.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	483,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	625,372,622.22	963,288,372.36
51	Засгийн газрын хувь оролцоо	625,372,622.22	963,288,372.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	818,720,719.00	818,720,719.00
51101	Өмч: - төрийн	818,720,719.00	818,720,719.00
512	Хуримтлагдсан үр дүн	(231,960,287.54)	105,955,462.60
51210	Өмнөх үеийн үр дүн	(231,960,287.54)	(231,960,287.54)
51220	Тайлант үеийн үр дүн	-	337,915,750.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	38,612,190.76	38,612,190.76
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	625,855,622.22	963,288,372.36

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,115,882,615.00	1,754,714,647.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,389,815.00	368,423,447.40
120	Нийтлэг татварын бус орлого	82,389,815.00	368,423,447.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	82,389,815.00	303,903,447.40
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		301,266,577.40
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		2,636,870.00
120009	Бусад орлого	00.00	64,520,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,033,492,800.00	1,386,291,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,033,492,800.00	1,386,291,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,033,492,800.00	1,386,291,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,064,712,434.39	1,416,692,700.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,064,712,434.39	1,416,692,700.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,050,309,118.00	1,300,788,250.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,330,590.00	950,342,970.56
210101	Үндсэн цалин	623,631,483.00	673,898,742.03
210102	Нэмэгдэл	113,030,317.00	226,170,619.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,424,177.00	23,325,000.00
210104	Урамшуулал	24,244,613.00	26,948,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,700,844.61	120,604,870.36
210201	Тэтгэврийн даатгал	71,334,844.61	81,840,835.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,082,923.92	10,078,784.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,268,464.51	7,822,272.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,548,342.07	1,896,707.41
210205	Эрүүл мэндийн даатгал	15,466,269.50	18,966,270.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,026,211.00	55,993,728.00
210301	Гэрэл, цахилгаан	4,366,986.00	5,219,062.00
210302	Түлш, халаалт	37,268,761.00	48,027,446.00
210303	Цэвэр, бохир ус	2,390,464.00	2,747,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,276,840.00	62,973,818.89
210401	Бичиг хэрэг	16,150,779.00	19,418,170.00
210402	Тээвэр, шатахуун	11,302,391.00	15,257,980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,793,430.00	13,518,348.89
210404	Ном, хэвлэл	00.00	960,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	485,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,407,990.00	13,219,320.00
210408	Бараа материал акалсны зардал	137,250.00	00.00
2105	Нормативт зардал	2,774,300.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,774,300.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,466,350.00	24,157,310.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,440,336.00	100,000.00
210604	Урсгал засвар	7,026,014.00	24,057,310.00
2107	Томилолт, зочны зардал	7,211,900.00	7,539,200.00

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	7,211,900.00	7,539,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,692,426.00	9,807,602.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,049,000.00	7,202,486.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	2,092,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,326.00	159,316.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	309,100.00	309,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,829,656.39	69,368,750.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,829,656.39	69,368,750.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,403,316.39	115,904,449.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,980,000.00	20,505,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,505,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,980,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,423,316.39	95,399,449.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,423,316.39	95,399,449.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	51,170,180.61	338,021,947.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	106,197.06
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	106,197.06
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-106,197.06
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	51,170,180.61	337,915,750.14

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,033,492,800.00	1,394,291,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	8,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,000,000.00
120009	Бусад орлого	00.00	8,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,033,492,800.00	1,386,291,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,033,492,800.00	1,386,291,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,033,492,800.00	1,386,291,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,019,880,300.00	1,385,714,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,019,880,300.00	1,385,714,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,005,476,983.61	1,269,810,350.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	786,330,590.00	950,342,970.56
210101	Үндсэн цалин	623,631,483.00	673,898,742.03
210102	Нэмэгдэл	113,030,317.00	226,170,619.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,424,177.00	23,325,000.00
210104	Урамшуулал	24,244,613.00	26,948,609.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,700,844.61	120,604,870.36

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	71,334,844.61	81,840,835.47
210202	Тэтгэмжийн даатгал	8,082,923.92	10,078,784.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,268,464.51	7,822,272.10
210204	Ажилгүйдлийн даатгал	1,548,342.07	1,896,707.41
210205	Эрүүл мэндийн даатгал	15,466,269.50	18,966,270.76
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,026,211.00	55,993,728.00
210301	Гэрэл, цахилгаан	4,366,986.00	5,219,062.00
210302	Түлш, халаалт	37,268,761.00	48,027,446.00
210303	Цэвэр, бохир ус	2,390,464.00	2,747,220.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,852,267.00	61,130,868.89
210401	Бичиг хэрэг	17,719,810.00	17,886,350.00
210402	Тээвэр, шатахуун	12,920,000.00	13,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,328,087.00	14,283,848.89
210404	Ном, хэвлэл	00.00	960,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	485,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,399,370.00	13,850,670.00
2105	Нормативт зардал	796,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	796,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,866,745.00	56,391,110.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,277,670.00	493,500.00
210604	Урсгал засвар	10,589,075.00	55,897,610.00
2107	Томилолт, зочны зардал	7,211,900.00	7,539,200.00
210702	Дотоод албан томилолт	7,211,900.00	7,539,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,692,426.00	9,807,602.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,049,000.00	7,202,486.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	847,000.00	2,092,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	143,326.00	159,316.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	309,100.00	309,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	8,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,403,316.39	115,904,449.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,980,000.00	20,505,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,505,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,980,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,423,316.39	95,399,449.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,423,316.39	95,399,449.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	13,612,500.00	8,576,400.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,612,500.00	576,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,612,500.00	576,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,612,500.00	576,400.00

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,612,500.00	576,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-13,612,500.00	-576,400.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	8,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,000,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-283,130,468.15	00.00	574,202,441.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-283,130,468.15	00.00	574,202,441.61
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	51,170,180.61	00.00	51,170,180.61
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-231,960,287.54	00.00	625,372,622.22
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-231,960,287.54	00.00	625,372,622.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	-231,960,287.54	00.00	625,372,622.22
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	337,915,750.14	00.00	337,915,750.14
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	818,720,719.00	38,612,190.76	105,955,462.60	00.00	963,288,372.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт-, хэмнэлт+	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,388,291,200.00	1,290,891,750.25	97,399,449.75	93.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,388,291,200.00	1,290,891,750.25	97,399,449.75	93.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,365,786,200.00	1,270,386,750.25	95,399,449.75	93.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,032,242,500.00	950,342,970.56	81,899,529.44	92.1
210101	Үндсэн цалин	695,428,400.00	673,898,742.03	21,529,657.97	96.9
210102	Нэмэгдэл	287,831,400.00	226,170,619.53	61,660,780.47	78.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,676,000.00	23,325,000.00	3,351,000.00	87.4
210104	Урамшуулал	22,306,700.00	26,948,609.00	-4,641,909.00	120.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,030,300.00	120,604,870.36	8,425,429.64	93.5
210201	Тэтгэврийн даатгал	87,740,600.00	81,840,835.47	5,899,764.53	93.3
210202	Тэтгэмжийн даатгал	10,322,400.00	10,078,784.62	243,615.38	97.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,257,900.00	7,822,272.10	435,627.90	94.7
210204	Ажилгүйдлийн даатгал	2,064,500.00	1,896,707.41	167,792.59	91.9
210205	Эрүүл мэндийн даатгал	20,644,900.00	18,966,270.76	1,678,629.24	91.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,705,000.00	55,993,728.00	711,272.00	98.7
210301	Гэрэл, цахилгаан	5,480,000.00	5,219,062.00	260,938.00	95.2
210302	Түлш, халаалт	47,782,000.00	48,027,446.00	-245,446.00	100.5
210303	Цэвэр, бохир ус	3,443,000.00	2,747,220.00	695,780.00	79.8
2104	Хангамж, бараа материалын зардал	62,223,300.00	61,130,868.89	1,092,431.11	98.2
210401	Бичиг хэрэг	18,225,700.00	17,886,350.00	339,350.00	98.1
210402	Тээвэр, шатахуун	12,042,300.00	13,550,000.00	-1,507,700.00	112.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,381,000.00	14,283,848.89	2,097,151.11	87.2
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	960,000.00	40,000.00	96.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	600,000.00	120,000.00	83.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,854,300.00	13,850,670.00	3,630.00	100.0
2105	Норматив зардал	783,700.00	00.00	783,700.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	783,700.00	00.00	783,700.00	-

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,000,000.00	56,967,510.00	32,490.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,100,000.00	1,069,900.00	30,100.00	97.3
210604	Урсгал засвар	55,900,000.00	55,897,610.00	2,390.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	7,578,000.00	7,539,200.00	38,800.00	99.5
210702	Дотоод албан томилолт	7,578,000.00	7,539,200.00	38,800.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,223,400.00	9,807,602.44	2,415,797.56	80.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,250,000.00	7,202,486.44	2,047,513.56	77.9
210803	Даатгалын үйлчилгээ	2,092,700.00	2,092,700.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	415,500.00	159,316.00	256,184.00	38.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	141,800.00	44,000.00	97,800.00	31.0
210807	Газрын төлбөр	323,400.00	309,100.00	14,300.00	95.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00	8,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,505,000.00	20,505,000.00	2,000,000.00	91.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,505,000.00	20,505,000.00	2,000,000.00	91.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,505,000.00	20,505,000.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	00.00	2,000,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,388,291,200.00	1,290,891,750.25	97,399,449.75	93.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,388,291,200.00	1,290,891,750.25	97,399,449.75	93.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,388,291,200.00	1,290,891,750.25	97,399,449.75	93.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	8,000,000.00	-8,000,000.00	#DIV/0!
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	38.00	38.00	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	05.00	05.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	38.00	38.00	0.00	100.0
650001	Терийн захиргааны албан хаагч (ТЗ)	16.00	16.00	0.00	100.0
650002	Терийн тусгай албан хаагч (ТТ)	12.00	12.00	0.00	100.0
650009	Терийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10.00	10.00	0.00	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газар нь “Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллагыг бататган бэхжүүлж хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино” эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Сум дундын Эрүүгийн хэргийн хэргийн анхан шатны шүүх, Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, Шүүхийн тамгын газар гэсэн бүтэц зохион байгуулалтай, 38 орон тоо батлагдаж 36 орон тоотой ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Дотоод аудитын газар нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020.12.22-ний өдрийн 174 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 963,288,3 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 337,432,7 мянган төгрөгөөр буюу 35 хувиар өссөн байгаа нь Шүүхийн гадна хөөсөн дулаалгын пассат болон дотор засвар хийснээр хөрөнгийг капиталжуулан сайжруулалтаар орлогоор бүртгэсэн нь өсөлттэй гарах шалтгаан болжээ.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	8,000.0	8,000.0
Авлага	483,0	0	(483,0)
Бараа материал	27,188,1	33,310,4	6,122,3
Үндсэн хөрөнгө	1,009,360.4	1,194,677.1	185,316.5
Хуримтлагдсан элэгдэл	411.17662	272.699.5	(138.477.3)

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нийт хөрөнгө	625,855,6	963,288,3	337,432,7
Өр төлбөр	483,0		(483,0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	625,372,6	963,288,3	337,915,7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	625,855,6	963,288,3	337,432,7

Эх сурвалж: Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансанд ахмадын санг 8,000.0 мянган төгрөг үүсгэж үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эхэнд 483,000 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст барагдуулж 0 үлдэгдэлтэй болсон.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,310,4 мянган төгрөг болж өмнөх оноос 6,122,3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 74,816,5 мянга, ШЕЗ-өөс 2,311,8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн, 0,3 мянган төгрөгийн шатахуун талоныг үнэ төлбөргүйгээр орлого авч бүртгэн үйл ажиллагаа явуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,194,677,1 мянган төгрөг болж 185,316,5 мянган төгрөгөөр өссөн нь нь Төсвийн хөрөнгөөр нийт 576.4 мянган төгрөгийн 3 нэр төрлийн үндсэн хөрөнгийг бэлтгэн, Шүүхийн ерөнхий зөвлөл болон ажлын албанаас 62,237.5 мянган төгрөгийн үнэ бүхий 31 нэр төрлийн үндсэн хөрөнгө бэлтгэн нийлүүлэгдсэн, барилгын гадна дулаалгын ажлыг мөн гүйцэтгүүлсэн, ТӨБЗГ-ын 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 305 дугаар тогтоолоор 38 нэр төрлийн 19,431.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг акталж данснаас хассан, 287 дугаар тогтоолоор 34 нэр төрлийн 188,520.6 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг данснаас хасаж үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн 64,520.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг буцаан орлогоор бүртгэлд тусгасан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант оны эхэнд 483,0 мянган төгрөгийн өглөгтэй байсныг барагдуулж оны эцэст өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 963,288,3 мянган төгрөг болж 337,915,7 мянган төгрөгөөр өссөн нь нь тайлант үеийн үр дүн 337,915,7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,535,933,1 мянга, нийт зарлагыг 1,535,933,1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 311,870,6 мянган төгрөгөөр бууруулж 1,224,062,5 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 1,388,291,2 мянган төгрөг болгож 164,228,7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70701 хөтөлбөрийн 80101, 80224, 80802 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,388,291.2 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,388,291.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, зарцуулагдаагүй 95,399.4 мянган төгрөгийг буцаан улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,290,891.7 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 95,399.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	70701 Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах	1,365,786.2	1,270,386.7	95,399.4	93.1
2	80101 үндсэн үйл ажиллагааны зардал	1,365,786.2	1,270,386.7	95,399.4	93.1
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	22,505.0	20,505.0	2,000.0	91.1
	Нийт дүн	1,388,291.2	1,290,891.7	97,399.4	93.1

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн 100030005401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

№	Хөтөлбөр	Эдийн засгийн ангилал	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгж илтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70701-80101	210101-210104	2022.01.03-2022.12.31	Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол, 2022 оны 05 –р сарын 11 өдрийн 193 дугаар тогтоолын дагуу Төрийн тусгай 10 алба хаагч, Төрийн захиргааны 16 албан хаагч, төрийн үйлчилгээний 10 алба хаагч, нийт 36 алба хаагчийн 1-12 дугаар сарын цалинг бодож олгосон.	92.1%	1,032,242,500	950,342,970.56
		210201-210205	2022.01.03-2022.12.31	Алба хаагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээ тайланг сар бүр төлж, өр авлагагүй ажилласан.	100%	129,030,300	120,604,870.36
		210301	2022.01.03-2022.12.31	Шүүхийн тамгын газрын гэрэл, цахилгааны зардлыг тоолуурын заалтын дагуу төлж барагдуулсан.	95.2%	5,480,000	5,219,000
		210302	2022.01.03-2022.12.31	РМБ ХХК-тай байгуулсан гэрээний дагуу түлш халаалтын зардлыг шилжүүлсэн.	100.5%	47,782,000	48,027,448
		210303	2022.01.03-2022.12.31	Чандмань-Баянхонгор ХК-ай байгуулсан гэрээний дагуу төлбөрийг 100 хувь шилжүүлсэн.	79.8%	3,443,000	2,747,220
		210401	2022.01.03-2022.12.31	ЗИХДЗШШүүх, СДЭХАШШүүх, СДИХАШШүүх, ЗХАШШүүх, Шүүхийн тамгын газрын үйл ажиллагаанд шаардагдах бичиг хэргийн материалаар хангаж, зардлыг шилжүүлсэн.	98.1%	18,225,700	17,886,350

**Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	2022.01.03- 2022.12.31	Шүүн таслах үйл ажиллагааг тасралтгүй явуулах чиг үүргийн дагуу шатахууныг зарцуулсан	112,5%	12,042,300	13,500,000
210403	2022.01.03- 2022.12.31	Монголын цахилгаан холбоо, Монгол шуудан ХК-тай байгуулсан гэрээний дагуу ажил үйлчилгээний төлбөр тооцоог барагдуулсан	87,2%	16,381,000	14,283,848.89
210405	2022.01.03- 2022.12.31	Цэвэр хот ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хог хаягдлын зардлын төлбөр тооцоог хийсэн.	83,3%	720,000	600,000.00
210406	2022.01.03- 2022.12.31	Байгууллагын цэвэрлэгээний бодис, шүүх хуралдааны цайны материалын зардлыг шилжүүлэн шүүгч, алба хаагчдын цэвэр тохитой орчинд ажиллах нөхцөл бололцоо хангагдсан.	100%	13,854,300	13,850,670
210503	2022.01.03- 2022.12.31	Шүүгчийн нөмрөг, шүүхийн захиргааны ажилтны дүрэмт хувцас, сантехникч, бичиг хүргэгчийн ажлын гуталаар хангах чиг үүрэгтэй ч хэмнэлтийн хуулийн дагуу зарцуулаагүй	0%	783,700	0
210601	2022.01.03- 2022.12.31	Тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах чиг үүрийн дагуу тоног төхөөрөмж худалдан авсан.	97.3%	1,100,000	1,069,900
210604	2022.01.03- 2022.12.31	Аймгийн Прокурорын байрыг шилжүүлэн авахтай холбогдуулан Шүүхийн шүүгч, захиргааны албан хаагчдын өрөө байрны хүрэлцээ мууг харгалзан урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэсэн \1,2,3 дугаар давхар, Шүүх хуралдааны танхимуудад\	100%	55,900,000	55,897,610
210702	2022.01.03- 2022.12.31	Шүүгч, албан хаагчдын албан томилолтоор ажилласан хугацааны зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу тооцон олгосон	99.5%	7,578,000	7,539,200

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан
 Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

2022 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын дарга М.Майжаргал, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Мөнхзул нар зурж байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 1,416,692.7 мянган төгрөгөөс 14,166.9 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 9,916.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд нийт 1,388,291.2 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	4	0	0
4	Сар бүр	3	36	36	0	0
5	Тухай бүр	8	96	96	0	0
6	Нийт	27	151	149	0	2

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 1,338,070.0 мянган

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан төгрөгийн 12 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 391,645.6 мянган төгрөгийн 35 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой төгрөгийн 11 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 34,294.0 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 1,933.5 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 32,294.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 66.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын даргын 2022.05.30-ны өдрийн 217 дугаар албан бичгээр хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,933.5	1	1,933.5	100
Албан шаардлага	2	32,294.5	2	32,294.5	100
Зөвлөмж	1	66.0	1	66.0	100
Нийт дүн	4	34,294.0	4	34,294.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 36,120.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 220.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 35,900.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

1.Цалингийн гүйлгээг давтан тооцоолоход 220.0 мянган төгрөгийн урьдчилгааг дутуу суутгасан байхад авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т заасан “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Шийдвэрлэсэн нь: Урьдчилгаа цалинг 2022.03.24-ний өдөр олгож буцаан суутгаагүй холбогдох албан хаагчаас суутган тооцож төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Прокурорын газрын байр буюу Шүүхийн тамгын газрын албан конторын 3 дугаар давхрыг шилжүүлэн авч дотоод засвар үйлчилгээг хийхээр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс төсвийн хуваарьт 2 удаагийн нэмэлт өөрчлөлтийг оруулж 35,900.0 мянган төгрөгийг баталж барилгын засвар үйлчилгээний ажлыг гэрээний дагуу хийж гүйцэтгүүлэхдээ тендер зарлахгүйгээр хэсэгчлэн шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14-д заасан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдөн, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

2. Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй бөгөөд гэрэл цахилгаанд 5,219.1 мянга, цэвэр бохир усны төлбөрт 2,747.2 мянга, халаалтын зардалд 48,027.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дозтор мэдээлнэ”, 6.4.8-д “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг цаг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урьдчилгаа 220.0 мянган төгрөгийг дутуу суутгасан байхад авлагаар тусгаагүй	1	220.0	1	220.0				
ТБОНӨХБАҮХУА ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн шууд худалдан авах ажиллагааны дээд хязгаарын дагуу бараа, ажил, үйлчилгээнд 20.0 сая байх заалтыг зөрчсөн	1	35,900.0			1	35,900.0	0	0
ДҮН	1	36,120.0			1	35,900.0	0	0

Баянхонгор аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим сайтад цахилгаан эрчим хүч, цэвэр бохир усаар үйлчлэх гэрээг байршуулаагүй	1	0					1	0
Дүн	1		0	0	0	0	1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	1	0	0	0	0	0	1	0

-oOo-